



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/675

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII/01 тоот тогтоол, аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны 01/86 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн 2022 оны "Өсвөрийн аврагч бүлгэм"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах чиглэлийн дагуу Булган аймгийн Онцгой байдлын газар, Дашинчилэн, Хутаг-Өндөр сум, Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулиудад сургалт арга зүйн танхим байгуулахад шаардагдах 40,000,000 (дөчин сая) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Сургалт, арга зүйн танхим байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (Хурандаа Ш.Баасандорж)-т, сургалтын танхим байгуулж, сургалт явуулах нөхцөл бололцоогоор хангаж ажиллахыг тус сургуулийн захирлуудад даалгасугай.

3. Шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах сангийн "Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ"-ний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
09 дүгээр сарын 25-ны өдрийн А/Б/С дугаар
захирамжийн хавсралт



ТАНХИМ БАЙГУУЛАХ ТӨСӨВ

| Д/д | Зардлын төрөл | Төсөв |
|-----|-----------------------------------|------------|
| 1 | 2 | 3 |
| 1 | Хангал сумын Хялганат тосгоны ЕБС | 9,369,000 |
| 2 | Хутаг-Өндөр сум ЕБС | 9,369,000 |
| 3 | Дашинчилэн сум ЕБС | 9,369,000 |
| 4 | ОБГ-ын сургалтын танхми | 11,893,000 |
| | Нийт | 40,000,000 |